



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын нэр: "Хөдөлмөр магадлах комиссын тахир дутуугийн тэтгэвэр тогтоолтын хэрэгжилт" хийх нийцлийн аудитын тайлан



Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээ шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.

Ховд хот
2018 оны 10 сар

<p>Тайланг бэлтгэсэн: Ховд аймаг дахь Төрийн Аудитын газар</p> <p>Тэргүүлэх аудитор Л.Галбадрах</p> <p>Аудитын менежер А.Цэцэгсүрэн</p> <p>Аудитор Д.Эрдэнэцэцэг Ц.Аззаяа</p> <p>2018 оны 10 дугаар сар</p> <p>Уг тайланг УАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.</p> <p>www.audit.mn</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70433061 дугаарын утас дугаарын факсаар харилцана уу?</p> <p>ХАЯГ: Ховд аймгийн ЗДТГ-ын байр 3 давхар 312 тоот</p>	<p>Товчилсон үгийн тайлбар3</p> <p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх, хамрах хүрээ, зорилт, арга зүй.....4</p> <p>Ерөнхий зүйл.....5</p> <p>Бүлэг 1.Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хурлын байр, тоног төхөөрөмж шаардлага хангаагүй хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх орчин нөхцөл бүрдээгүй байна.....6</p> <p>1.1. Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын гишүүдийн гэрээ дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсруулан батлаагүй, эмч нарын сонгон шалгаруулалтын материал байхгүй байна.....7</p> <p>1.2 Хөдөө орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ажил шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.....8</p> <p>Бүлэг 2.Орон нутгийн эмнэлэг магадлах комиссын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.11</p> <p>2.1 Хөдөө орон нутагт хүн амын хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан нөхцөлийг судлах, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар хийгдсэн судалгаа байхгүй байна.....12</p> <p>2.2 ЭХМК-ын үйл ажиллагаанд хөндлөнгийн болон дотоод хяналт хэрэгжээгүй, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаагүй, хөндлөнгийн хяналт хийгдэж зөвлөмж өгөгдөөгүй байна.....13</p> <p>Дүгнэлт.....15</p> <p>Зөвлөмж.....16</p> <p>Тэргүүлэх аудиторовын тушаал17</p> <p>Зөрчлийн жагсаалт.....18</p> <p>Байгууллагын санал.....18</p>
---	--

Товчилсон үгийн тайлбар:

Товчилсон үг	Тайлбар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
НАГ	Нийцлийн аудитын газар
ХХНХЯ	Хөдөлмөр халамж нийгмийн хамгааллын яам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ЭХМК	Эмнэлэг хөдөлмөр магадлах комисс
НДГ	Нийгмийн даатгалын газар
ХХҮГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ТДТ	Тахир дутуугийн тэтгэвэр
ХЧА	Хөдөлмөрийн чадвар алдалт
ОУХБИӨ	Олон улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөр
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	
Хүснэгт-1	Аймгийн ХБИ-ийн тоо мэдээлэл
Хүснэгт-2	11 сумын иргэдээс авсан судалгааны дүн
Хүснэгт-3	ХБИ-ний 2015-2017 оны өвчлөлийн харьцуулалт
Хүснэгт-4	ХБИ-ий 2015-2017 онуудтай харьцуулсан судалгаа
Хүснэгт-5	Баруун 5 аймгийн ХБИ-ний судалгаа, харьцуулалт
Хүснэгт-6	ХБИ-дэд олгосон төсөв гүйцэтгэл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй:

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2018 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 06 тоот тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт: Хөдөлмөр магадлах комиссын тэтгэвэр тогтоолтын хэрэгжилтийн үр дүнг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Хөдөлмөр магадлах комисс тахир дутуугийн тэтгэвэр тогтоолтын үйл ажиллагааг заавар журам, дүрэмд заасны дагуу хуульд нийцүүлэн хэрэгжүүлсэн эсэх,
- Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагааны чанар, хүртээмжтэй байдал, үйл ажиллагаанд нь тавих дотоод хяналтыг хэрэгжүүлсэн эсэх

Аудитын хамрах хүрээ: Аудитад Нийгмийн даатгалын хэлтэс, БОЭТөв, ХХҮГазрууд, аймгийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах орон нутгийн комиссын 2017 оны үйл ажиллагаа болон бусад холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг хамруулна. Аудитаар мэргэжлийн шинжээч авч ажиллуулах санхүүгийн нөөц, цаг хугацаа хомсоос шалтгаалж хөдөлмөр магадлах комиссын өвчний онош тогтоолттой холбоотой асуудлыг хамруулаагүй болно.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд төрийн хяналт, шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/-ийг ашиглах, холбогдох газар, эмнэлгүүдийн холбогдох албан тушаалтнууд болон ажилтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, үйл ажиллагааны тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Шалгуур үзүүлэлтүүд: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль; Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль; Нийгмийн даатгалын тухай хууль; Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмж төлбөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм, Эрүүл мэнд спортын сайд, ХХНХ-ын сайдын 342 тоот тушаал болон бусад холбогдох дүрэм, журам, засгийн газрын тогтоолууд

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн: Аудитыг Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Х.Болбаатар удирдан, аудитын менежер А.Цэцэгсүрэн аудитын арга зүйгээр хангаж, үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, Аудитор Д.Эрдэнэцэцэг, Ц.Аззаяа нар гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл: Аудитын тайланг ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал гэсэн агуулгаар бичлээ.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын зорилт нь ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас иргэн хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу хагас (хэсэгчлэн) алдсан шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдсан хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх, ажлын цагийг богиносгох асуудлыг магадлан шийдвэрлэхэд оршиж байна.

Эмнэлгийн хөдөлмөр магадлах комиссын бүрэлдэхүүнд зөвлөлийн дарга 1, орлогч дарга 1, нарийн бичиг 1, магадлагч эмч 1, ХХҮГазраас 1, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 1, мэдрэлийн эмч 1, дотрын эмч 1, мэс заслын эмч 1, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр хөдөлмөрийн чадвар алдсан хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх, ажлын цагийг богиносгох асуудлуудыг хэлэлцэн шийдвэр гарган ажиллаж байна

Аймгийн хэмжээнд тахир дутуугийн тэтгэвэртэй 3372 иргэн бүртгэлтэй байгаагаас тэтгэврээ сунгуулсан 2375, шинээр тогтоолгосон 485, хасагдсан 365, шилжиж ирсэн 8, шилжиж явсан 30, нас барсан 109 иргэн байна. Үүний 2042 нь нийгмийн даатгалын хэлтсээс, 1330 иргэн нь нийгмийн халамжаас тэтгэвэр авч байна. 2017 онд давхардсан тоогоор 342 иргэн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хуралд оролцоогүй байна. .

Аймгийн ЭХМК нь 2017 онд нийт 44 удаа хуралдаж нийт 2532 ширхэг актын маягт зарцуулсан байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолтын тайлангийн дүнгээс харвал 70-аас дээш хувиар 1044, 70-аас доош хувиар 1824 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын актыг дахин сунгаж ажилласан байна.

2017 онд аймгийн нийгмийн даатгалын сангаас 1596 хүнд 4280.1 сая төгрөг, аймгийн халамжийн сангаас 1272 хүнд 1871.5 сая төгрөг нийт 6151.6 сая төгрөг олгосон байна.

2017 онд 485 иргэнд шинээр хөдөлмөрийн чадвар алдалтын акт тогтоож ажилласнаас 70-аас дээш хувиар 133, 70-аас доош хувиар 352 иргэнд шинээр хөдөлмөрийн чадвар алдалт тус тус тогтоожээ. Энэ хугацаанд 8 хөгжлийн бэрхшээлтэй иргэн шилжиж ирсэн бол 30 иргэн шилжиж явсан ба нас барсан 109 иргэний бүртгэл мэдээллийг баталгаажуулсан байна.

Жилийн дүнгээр улсын дундажтай харьцуулахад 3.3 хувь буюу нийт 2868 хөгжлийн бэрхшээлтэй иргэн мэдээллийн баазад бүртгэлтэй байна.

Өмнөх онуудаас сэтгэц, дотрын өвчин, мэдрэлийн өвчин, ослын шалтгаантай бэртэл гэмтэл мэс заслын өвчин, чих, хамар, хоолойн өвчний тоо өссөн дүнтэй байна.

Бүлэг 1: Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хурлын байр, тоног төхөөрөмж шаардлага хангаагүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх орчин нөхцөл бүрдээгүй байна.

Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын гишүүдийн гэрээ дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсруулан батлаагүй байна.

- 1.1** Аймгийн Эмнэлгийн хөдөлмөр магадлах комисс нь хөдөлмөрийн чадвар алдсан хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх, ажлын цагийг богиносгох асуудлыг магадлан шийдвэрлэх 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж нарийн мэргэжлийн эмч болох мэдрэл, дотор, мэс заслын эмч нартай хөдөлмөрийн гэрээ байгуулсан бөгөөд бусад багийн гишүүдтэй үр дүнгийн гэрээ байгуулаагүй байгаа нь ЭХМК-ын дүрмийн ¹2.6-дахь заалтын дагуу үр дүнгийн гэрээ байгуулж ажлын үр дүнг тооцож ажиллаагүй байна. 2017 онд комиссын гишүүдийн ажилласан цагийн урамшуулал, бусад зардалд 15.6 сая төгрөгийн төсөв батлагдаж 15.6 сая төгрөг зарцуулсан байна.
- 1.2** Аймгийн ЭХМК-д ажиллах төрөлжсөн мэргэжлийн эмч нарыг 2015 оны жилийн эцсийн тайланд дурдсанаар Засгийн газрын 2015 оны 11 тоот тогтоолоор баталсан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2015 оны А/55 тушаалыг хэрэгжүүлэх үүднээс аймгийн Засаг даргын 2015 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/426 тоот захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй сонгон шалгаруулах байнгын ажлын хэсэг байгуулан явуулжээ. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Эрүүл мэндийн газрын дарга, Нийгмийн даатгалын хэлтсийн дарга, БОЭТ-ийн захирал, аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн, Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн тус тус орж ажилласан байгаач нарийн мэргэжлийн эмчийн сонгон шалгаруулалтад ирүүлсэн материал байхгүй, хурлын тэмдэглэл, сонгон шалгаруулалтын тайлан гарын үсгээр баталгаажаагүй байна. Энэ нь Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрмийн ²3.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- 1.3** Хөдөлмөрийн чадвараа алдсан 2868 иргэдийн мэдээллийн цахим санг бүрдүүлж ажилласан байна. Нийт хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн 2033 буюу 71,3 хувь нь ид хөдөлмөрлөх 21-50 насны иргэд байгаагаас хүн ам цөөтэй хөдөө орон нутагт сэтгэцийн өвчлөл их байгаа нь анхаарал татаж байна. ХБИ-ийн мэдээлэл цахим программд мэдээлэгдсэн байгаа нь ЭХМК-ын дүрмийн ³6.1.4-д заасан хадгалалт,

¹ "Төв комиссын дарга нь салбар комиссын даргатай, орон нутгийн болон салбар комиссын дарга нь тус тусын комиссын гишүүдтэй үр дүнгийн гэрээ байгуулан, ажлын үр дүнг тооцож ажиллана."

² Нийгмийн даатгалын төв байгууллага нь Төв комиссын (орон тооны бус) шинжээч эмч нарын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, дүнг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ

³ "Тухайн орон нутгийн хөдөлмөрийн чадвараа алдсан иргэний мэдээллийн цахим санг бүрдүүлж, тухай бүр шинэчлэх, хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа хийх, дүгнэлт гаргах, мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах;"

хамгаалалт иргэдийн мэдээлэл бүрэн орсон байна. Аймгийн хэмжээнд цахим санд бүртгэлтэй байгаа тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгосон иргэдийг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт -1/

Аймгийн тахир дутуугийн тэтгэвэр тогтоолт өвчлөлийн ангилалаар хүн амын тоотой харьцуулсан судалгаа											
№	Сумдууд	Хүн амын тоо	ХБИ-ийн тоо	Гэмтэл согогийн өвчин	Дотрийн өвчин	Мэдрэлийн өвчин	Мэс заслын өвчин	Нүдний өвчин	Сэтгэцийн болон зан үйлийн эмгэг	Чих, хамар, хоолойн өвчин	ХБИ-ийг хүн амын тоотой харьцуулсан хувь
1	АЛТАЙ	3219	96	9	20	8	10	11	32	6	2.98
2	БУЛГАН	10126	278	26	36	54	25	28	81	28	2.75
3	БУЯНТ	3644	90	6	26	10	14	4	22	8	2.47
4	ДАРВИ	3013	102	14	11	21	13	6	23	14	3.39
5	ДӨРГӨН	3044	114	9	12	22	18	9	27	17	3.75
6	ДУУТ	2058	83	6	23	13	14	8	9	10	4.03
7	ЖАРГАЛАНТ	29800	1121	97	311	174	147	94	180	118	3.76
8	ЗЭРЭГ	3245	112	13	21	19	6	19	22	12	3.45
9	МАНХАН	4217	103	12	12	16	17	12	21	13	2.44
10	МӨНХХАЙРХАН	2216	67	3	17	9	12	7	14	5	3.02
11	МӨСТ	3144	88	7	24	15	11	5	20	6	2.80
12	МЯНГАД	3630	130	10	27	18	13	12	23	27	3.58
13	ҮЕНЧ	4091	124	13	20	18	14	11	40	8	3.03
14	ХОВД	3554	87	6	15	15	20	10	16	5	2.45
15	ЦЭЦЭГ	3051	83	8	17	13	8	9	21	7	2.72
16	ЧАНДМАНЬ	2937	94	7	21	16	8	7	21	14	3.20
17	ЭРДЭНЭБҮРЭН	2374	96	5	21	15	16	16	15	8	4.04
	Нийт дүн	87363	2868	251	634	456	366	268	587	306	3.28

ХЧА-ын байдалд судалгаа хийхэд сэтгэц, дотор, мэдрэл, гэмтэл, нүдний өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан иргэд хамгийн олон тохиолдол бүртгэгдэж, нийт хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэж буй өвчлөлийн 71.6 хувийг эзэлж байгаа статистик мэдээлэл байна. Нийт хүн амын 3.28 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна.

1.4 Иргэний бүртгэл мэдээллийн байгууллагатай хамтран хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийн шилжилт хөдөлгөөн, нас баралтын мэдээллийг авч харилцан ажиллаж байгаа ч иргэний мэдээллийг цахим бүртгэлд орсон дор шууд холбогдож авах боломжгүй, хөдөөгийн иргэдийн ХЧА-ын байдалд дүгнэлт хийх, хүрч ажиллах санхүүгийн боломжгүй, комиссын гишүүдийн үр дүнг дүгнээгүй, урамшууллаас ХАОАТ-ын хөнгөлөлт илүү суутгасан байна. Тухайлбал:

- ✓ ЭХМК-ийн гишүүдийн урамшууллаас ХАОАТ-ын 7.0 мянган төгрөг чөлөөлсөн нь хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн ⁴24.1-дэхь заалтыг зөрчсөн, урамшуулал илүү олгосон нийт 634,2 мянган төгрөг, хурлын тэмдэглэлгүй цагийн хөлс олгосон 1,9 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 заалттай нийцэхгүй байна.
- ✓ Нарийн мэргэжлийн эмч нартай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан боловч бусад гишүүдтэй гэрээ байгуулаагүй, гэрээ дүгнэх ЭХМК-ын дүрмийн ⁵5.2 дахь заалтыг мөрдөж ажиллаагүй байна.
- ✓ Эрүүл мэндийн газар, БОЭТ-ийн байранд байршуулж зарим эмч нартай холбогдож урих байдлаар урилга зар мэдээгээ ил тод байдлаар сурталчилсан гэж байгаа боловч баримт материал байхгүй байна.

Хөдөө орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ажил шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.

1.5 Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүн шаардлагатай хууль зүйн зөвлөгөө, тусламж үйлчилгээгээр үнэ төлбөргүй хангагдах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ хөдөө орон нутагт ялангуяа алслагдсан сум, багийн иргэдэд хүрч очихгүй байна. Орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай хуулийн ⁶20.1-д зааснаар хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ажил шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаа нь дараах судалгаагаар харагдаж байна.

/ Хүснэгт-2/



⁴ Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт 84000 төгрөгийг албан татварын хөнгөлөлт үзүүлнэ"

⁵ Сонгон шалгаруулалт зохион байгуулсан Нийгмийн даатгалын байгууллага нь гэрээ дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсруулан баталж, дүгнэж ажиллана.

⁶ "Төрөөс хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ"

Дээрх судалгаанаас харахад аймгийн 11 сумын давхардсан тоогоор 879 иргэнээс авсан судалгаанаас харахад ЭХМК-ын үйл ажиллагаа, үйлчилгээ, орчин нөхцөл бүрдээгүй гэж 469 хүн хангалтгүй гэж хариулсан байна. /Судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэдний ар гэр, сумын иргэд оролцсон./

1.6 Хөдөлмөрийн чадвараа алдсан 2868 иргэдээс тэтгэвэр, тэтгэмж авч байгаа 328 хүний хувийн хэргийг түүвэрлэн эмнэлгийн хуудас заавар журмын дагуу үнэн зөв бичигдсэн эсэх, онош тухайн даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, өөрчлөлттэй тохирч байгаа эсэхийг Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн А/39, А/12 тоот хамтарсан тушаалын нэг, хоёрдугаар хавсралтаар баталсан жагсаалттай тулган шалгалаа. Хувийн хэргийг түүвэрлэн шалгахад ЗДТГазраас эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн Н.Дорж, Эрүүл мэндийн газраас орлогч дарга Х.Оюунцэцэг нар хөндлөнгийн шинжээчээр ажиллалаа. Хөдөлмөрийн чадвараа 50 болон түүнээс дээш хувиар алдсан тохиолдолд иргэд нийгмийн халамжийн болон даатгалын үйлчилгээ авах нөхцөл бүрддэг, тэтгэврээс хасагдсан иргэд нь нас барсан, шилжсэн, хугацаа дууссан шалтгаанаар хуулийн дагуу сунгагдаагүй байна.



Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтыг өвчлөлийн ангиллаар харуулбал:

/Хүснэгт-3/

Хөдөлмөрийн чадвар алдалт 2015-2017 оны байдлаар хамгийн их тэтгэвэр тогтоолгосон өвчлөл						
Д/д	2015 он	Хүний тоо	2016 он	Хүний тоо	2017 эхний хагас жил	Хүний тоо
1	Сэтгэцийн эмгэг	459	Сэтгэцийн эмгэг	475	Сэтгэцийн эмгэг	587
2	Дотрын өвчин	771	Дотрын өвчин	782	Дотрын өвчин	798
3	Мэдрэлийн өвчин	372	Мэдрэлийн өвчин	351	Мэдрэлийн өвчин	456
4	Гэмтэл согогийн өвчин	286	Гэмтэл согогийн өвчин	319	Гэмтэл согогийн өвчин	306
5	Нүдний өвчин	253	Нүдний өвчин	181	Нүдний өвчин	268
	Дүн	2141 буюу 63.4%		2108 буюу 62.5%		2415 буюу 71.6%

ЭХМК-ын дүрмийн 76.1.1-д заасны дагуу тэтгэвэр тогтоолтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд аудитын явцад тахир дутуугийн тэтгэвэр авч байгаа иргэдийн хувийн хэрэгт байгаа тэтгэмж тогтоосон актыг өвчний жагсаалт

⁷ "Иргэний хөдөлмөрийн чадвараа алдсан шалтгаан, түүний хувь хэмжээг тогтоох, хугацааг сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх, ажлын цагийг богиносгох асуудлыг эрүүл мэндийн байгууллагын Эмнэлэг хяналтын комиссын шийдвэрийг үндэслэн тогтоох"

кодтой тулган шалгахад зөрүү гараагүй боловч тухайн иргэний өвчний карттай тулган баталгаажуулах боломжгүй байлаа. Дээрх хүснэгтээс харахад хамгийн их өвчлөл дотор, сэтгэц эмгэгийн өвчлөл байгаагаас сэтгэц эмгэгийн өвчлөл, мэдрэлийн өвчлөл жил бүр өссөн үзүүлэлттэй байна.

1.7 ЭМК нь тусгайлсан ажлын өрөөгүйгээс тахир дутуугийн групп тогтоох, сунгах, цуцлах 1 дүгээр хурлыг БОЭТ-ын жижүүр эмч нарын өрөөнд, 2 дугаар шатны хурлыг нярвын өрөөнд хийж ирсэн байна. Групп тогтоолгохоор ирсэн хөгжлийн бэрхшээлтэй хүнд өвчтэй иргэд зай багатай, агааржуулалт байхгүй өрөөнд хуралд орж, гадаа зааланд өдөржин хүлээдэг, ХБИ-ийн орж гарах зам байхгүй, бие засах газаргүй, стандарт бус байранд үйл ажиллагаа явуулж байгаа нь ЭХМК-ын дүрмийн ⁸4.2.4-д заасан заалтын хэрэгжилт хангагдаагүй байна.



Аймгийн ЭХМК-оос хурал хийх стандарт шаардлагад нийцсэн байртай болохоор 2017/07/19-ны 448 тоот албан бичиг өгснөөр аймгийн ЗДТГазраас ЭХМК-ын хурал хийх байрыг хуучин Асрамжийн байр байсан өрөөнд шийдэж өгсөн боловч хурал хийх нөхцөл боломжгүй, эрүүл ахуйн шаардлага хангаагүй үйлчилгээ үзүүлэх боломжгүй байна. Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдэд үзүүлэх үйлчилгээ биеийн онцлог шаардлагад нийцсэн орчин нөхцөл бүрдээгүй байгаа дараах зөрчлүүд байсаар байна.Тухайлбал:



- ✓ *Орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ажил дутагдалтай, сэргээн засах төв байхгүй*
- ✓ *Эрүүл мэндийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ тэдний онцлог хэрэгцээ, шаардлагыг хангасан хүртээмжтэй орчин, техник, тоног төхөөрөмжөөр хангагдаагүй*
- ✓ *Хөгжлийн бэрхшээлтэй хүн эрүүл мэндийн үйлчилгээ авах, нийгмийн бүхий л харилцаанд оролцохыг дэмжих дэд бүтэц, зам тээвэр, мэдээллийн технологийн хүртээмж байхгүй.*
- ✓ *ЭХМК-ын гишүүд тахир дутуугийн тэтгэвэр тогтоох, сунгах, цуцлах хурал хийх стандарт шаардлагад нийцсэн байр байхгүй, иргэдэд үйлчлэх эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөл бүрдээгүй байна.*

⁸ "Эмнэлэг хөдөлмөрийн магадлах үйл ажиллагааг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах"

Бүлэг 2.Орон нутгийн эмнэлэг магадлах комиссын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Сумдын хүн амын хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан нөхцөлийг судлах, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар хийгдсэн судалгаа хангалтгүй байна.

2.1 Нийт хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн 36 хувь нь хөдөлмөрийн чадвараа бүрэн, 64 хувь нь хагас алдсан байна. Ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан болж буй 18 бүлэг өвчнөөс 5 бүлэг өвчин нь нийт хөдөлмөрийн чадвар алдалтын 71.6 хувийг эзэлж хөдөлмөрийн чадвар алдалтын тэргүүлэх шалтгаан болж байна. ХЧА-ын шалтгаан, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар хийсэн ажил байхгүй байгаа нь ЭХМК-ын дүрмийн ⁹8.1.6-д заасан заалт хэрэгжихгүй байгааг харуулж байна. ЭХМК-ын 2015-2017 оны байдлаар гаргасан тахир дутуугийн тэтгэвэр тогтоолтын талаар хийсэн судалгааг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт-4/

Аймгийн хэмжээний хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаа														
Аймаг (дүүрэг)-ийн нэр	он	Нийт хүн ам	ХБИ-ийн тоо	Хүйс		Зонхилон тохиолдох өвчнөөр					ҮО	МШӨ	Тэтгэвэр тэтгэмж	
				Эр	Эм	Дотор	Сэтгэц	Нүд	Мэдрэл	Гэмтэл			НДС	Халам
Ховд	2015	83127	2940	1679	1264	601	459	253	372	286	20	0	1685	1255
	2016	85325	3198	1695	1313	617	475	181	351	319	13	0	1516	1682
	2017	87363	2868	1573	1295	525	517	245	325	285	27	0	1596	1272

Хөдөлмөрийн чадвар алдалтыг өвчний ангилалаар авч үзвэл сэтгэц эмгэгийн өвчин 2015 оноос 1.11 хувиар, 2016 оноос 1.63 хувиар, дотрын өвчин 2015 оноос 0.68 хувиар өсч 2016 оноос 1.2 хувиар буурч, гэмтэл согогийн өвчин 2015 оноос 0,82 хувиар өсч 2016 оноос 0,29 хувмар буурсан, нүдний өвчин 2015 оноос 0,22 хувиар буурч 2016 оноос 2,24 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2.2 ЭХМК-нь 2017 онд эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаатай холбоотой 4 иргэний өргөдөл гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд эмнэлгийн хуудас заавар журмын дагуу үнэн зөв бичигдсэн эсэх, онош тухайн даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, өөрчлөлттэй тохирч байгаа эсэхийг үндсэн баримт бичигтэй нь тулган шалгаж хариуг өгсөн байна. Аудитын явцад иргэдээс санал судалгаа авч байхад өргөдөл гомдлын шинжтэй 13 хүний санал ирсэн тул ЭХМК-д танилцуулж шийдвэрлүүлэхээр шилжүүлээ.

ЭХМК-нь иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой үйл ажиллагааг дэмжиж, холбогдох байгууллагатай хамтран ажиллах, иргэдийн санал хүсэлтийг сонсох

⁹ Тухайн нутаг дэвсгэрийн хүн амын хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, нөхцөлийг судлах, түүнээс урьдчилан сэргийлэх талаарх судалгаа, шинжилгээний ажлыг дэмжих"

үйл ажиллагаа хангалттай хэрэгжээгүй, хөдөлмөрийн чадвараа хугацаагүйгээр алдсан нь тогтоогдсон иргэний эрүүл мэндийн байдал, түүнд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний талаарх судалгааг магадлагч эмч харьяалагдах өрх болон сумын эмчээс хагас, бүтэн жилээр авч, хяналт тавьж ажиллаагүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх үйлчилгээг сайжруулах ажил хангалтгүй, мэдээ мэдээлэл бүрэн хүрч очихгүй байгаа нь ЭХМК-ын дүрмийн ¹⁰7.1.2-дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх үйлчилгээ бусад аймагт хэрхэн хэрэгжиж байгаа талаар мэдээлэл авч чадаагүй боловч ХБИ-ын тоо судалгааг Төв комиссын тайлан мэдээ судалгаанаас авч харьцуулалт хийлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоо судалгааг баруун 5 аймгийн хүн амын тоотой харьцуулж хүснэгтээр харуулбал: /Хүснэгт-5/

ХБИ-ний баруун 5 аймгаар харьцуулсан судалгаа						
№	Аймаг	ХЧА хүний тоо			ХБИ-ийн эзлэх хувь	
		Хүн амын тоо	2016	2017	2016	2017
1	Ховд	87363	3198	2868	3.66	3.28
2	Баян-Өлгий	102644	7877	8251	7.67	8.04
3	Говь-Алтай	57484	2964	2848	5.16	4.95
4	Завхан	71551	3810	3810	5.32	5.32
5	Увс	82688	4419	4230	5.34	5.12

Дээрхи судалгаанаас харахад 2017 онд хамгийн их хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй аймаг Баян-Өлгий аймаг байгаа бөгөөд хүн амын 8.04 хувийг эзэлж байхад манай аймаг 3.28 хувийг эзэлж байна.

2.3 Аймгийн хэмжээнд 2017 онд Нийгмийн даатгалын сангаас 1596 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 4204.1 сая төгрөг, Халамжийн сангаас 1272 иргэнд 1871.5 сая төгрөг тус тус зарцуулсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон саанхүүжилтийг хүснэгтээр харуулбал: /Хүснэгт-6/

2016-2017 онд ХБИ-дэд олгосон санхүүжилт									
Д/д	Он	Халамж				Нийгмийн даатгал			
		Хүний тоо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хүний тоо	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	2016	1,682	2,300.0	1,792.8	507.2	1,516	4,464.8	4,204.1	260.7
3	2017	1,272	2,792.4	1,871.5	920.9	1,596	4,284.7	4,280.1	4.6
ДҮН		2,954	5,092.4	3,664.3	1,428.1	3,112	8,749.5	8,484.2	265.3

Дээрхи хүснэгтээс харахад 2016 онд Халамжийн төсөв 2300.0 сая төгрөгөөр батлагдаж 1792.8 сая төгрөг зарцуулж 507.2 сая төгрөг хэмнэсэн, 2017 онд 2792.4 сая төгрөг батлагдаж 1871.5 сая төгрөг зарцуулж 920.9 сая төгрөг хэмнэсэн, Нийгмийн даатгалын сангаас 2016 онд 4464.8 сая төгрөг

¹⁰ комиссыг үйл ажиллагаа явуулах байраар хангаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, комиссын гишүүдийн ажиллах нөхцөлийг сайжруулах талаар шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

батлагдаж 4204.1 сая төгрөг зарцуулж 260.7 сая төгрөг хэмнэсэн, 2017 онд 4284.7 сая төгрөг батлагдаж 4280.1 сая төгрөг зарцуулж 4.6 сая төгрөг хэмнэсэн байгаа нь ХБИ-д олгох санхүүжилт батлагдсан төсвийн хэмжээнд хэмнэлттэй зарцуулагдаж байна. Хэмнэгдсэн гол шалтгаан нь нас барсан, шилжин явсан, цуцлагдсан иргэний тооноос хамаарч байна.



2.4.ЭХМК-нь аймгийн ХБИ-ийн холбоотой хамтран ОУ-ын ХБИ-ын эрхийг хамгаалах өдрийг угтсан өдөрлөг арга хэмжээнд 210 орчим ХБИ-д мэдээлэл өгч санал хүсэлтийг нь сонсож, Ховд эм холбооны удирдлагуудтай хамтран иргэдийг витаминжуулж БОЭТ-ийн эмч нарын хамт эрүүл мэндийн үзлэгт хамруулж зөвлөгөө өгч ажилласан байна. Гэвч



хөдөө алслагдсан сум, сумын төвөөс хол амьдарч байгаа ХБИ-дэд тахир дутуугийн групп тогтоолт, сэргээн засах үйл ажиллагааны тухай болон хуулийн талаар мэдээ мэдээлэл хүрч очихгүй байна. Сумын байцаагч нар хөрөнгө санхүүгийн боломж байхгүйгээс иргэдэд мэдээлэл хүргэх, сургалт зохион байгуулах боломжгүй, санал санаачлага дутмаг, иргэдэд хүрч ажиллахгүй, хөдөө орон нутгийн иргэдэд үзүүлэх үйлчилгээ дутмаг байгаа зөрчил байна.

Тухайлбал:

- ✓ *Анхан шатны нэгж болох өрхийн эмнэлгүүд суурь судалгаа ирүүлээгүй, ХЧА-ын шалтгаан, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар хийсэн ажил хангалтгүй, хурлын үйл ажиллагааг боловсронгуй болгох техник тоног төхөөрөмж дутагдалтай, стандарт шаардлага хангасан байргүй, ачаалал ихтэй байдаг учир чанартай үйлчилгээг иргэдэд хүргэж чадахгүй байгаа*
- ✓ *Алслагдсан сум, сумын төвөөс хол амьдарч байгаа ХБИ-дэд тахир дутуугийн групп тогтоолт, сэргээн засах үйл ажиллагааны тухай болон хуулийн талаар мэдээ мэдээлэл хүрч очдоггүйгээс иргэд тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгож чадахгүй байна.*
- ✓ *Сумын байцаагч нар хөрөнгө санхүүгийн асуудал байхгүйгээс иргэдэд мэдээлэл хүргэх, сургалт зохион байгуулах боломжгүй, санал санаачлага дутмаг, иргэдэд хүрч ажиллахгүй байна.*

ЭХМК-ын үйл ажиллагаанд хөндлөнгийн болон дотоод хяналт хэрэгжээгүй, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаагүй, хөндлөнгийн хяналт хийгдэж зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.5 ЭХМК-оос 2017 онд цахим программд бүртгэлтэй боловч тэтгэвэр авдаггүй 338 иргэдийн хөдөлгөөнийг Улсын бүртгэлийн хэлтсийн шилжилт хөдөлгөөн хийсэн иргэдийн мэдээлэлтэй тулгаж үзээд 249 иргэний хөдөлгөөнийг мэдээллийн баазад шинэчилж оруулсан, үлдсэн 89 иргэний 18 нас барсан, 69 цуцлагдсан, 1 шилжсэн, 1 мэдээлэл давхардсан байсан зөрчлийг арилгаж ажилласан боловч мэргэжлийн байгууллагууд ЭХМК-ын үйл ажиллагаанд дотоод хяналт хийгээгүй байгаа нь тайлбар мэдээлэл авах, үүрэг даалгавар өгөх, мэргэжлийн ур чадварыг сайжруулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөвлөмж зөвлөгөө өгөх үндсэн чиг үүргээ биелүүлээгүй байна. Энэ нь ЭХМК-ын дүрмийн ¹⁵5.1.10-д заасан заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.6 Ховд аймгийн хэмжээнд ХБИ-ийн эрх ашгийг хамгаалсан Хараагүй иргэдийн холбоо, Тахир дутуу иргэдийн холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн холбоо гэсэн ТББ-ууд ажилладаг гэх боловч хийж хэрэгжүүлсэн ажлын талаар ажлын тайлан, санал хүсэлт ирүүлсэнгүй. ХБИ-ийн холбооны тэргүүн тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгох хуралд оролцож хөндлөнгийн хяналт хийдэг боловч хяналт хийсэн тэмдэглэл тайлан ирүүлсэнгүй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл иргэний эрх зөрчигдөж байгаа эсэхэд хяналт тавьж чадаагүй байгаа нь ЭХМК-ын дүрмийн ¹⁶6.2-дахь заалт хэрэгжээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж ажиллаагүй байна.



2.7 ЭХМК-ын үйл ажиллагаанд стандарт шаардлага тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч эрүүл ахуйн орчин нөхцөлийг бүрдүүлэх хяналт хийгдээгүйгээс комиссын гишүүд сургалтад хамрагдаж мэдлэг ур чадвараа дээшлүүлэх боломжгүй, хурал хийх орчин нөхцөл бүрдээгүй, ажлын цагийн хөлс бага, олон цагаар агааргүй орчинд суудаг, иргэдэд мэдээлэл өгөх, ганцаарчилсан уулзалт хийх боломжгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрийн биеийн онцлогт тохирсон үйлчилгээ авч байгаа эсэх, комиссын гишүүдийн ажиллах орчин нөхцөл

¹¹ "орон нутгийн болон салбар комиссын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, хяналт шалгалт хийх, явцын болон бүрдмэл магадлал, ижил мэргэжилтний үзлэг хийх, тайлбар мэдээлэл авах, үүрэг, даалгавар өгөх, мэргэжлийн ур чадварыг сайжруулж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутгийн болон салбар комиссын гишүүдийг сэлгүүлэн ажиллуулах санал гаргаж шийдвэрлүүлэх"

¹² . Комиссын бүрэлдэхүүнд орсон нийгмийн халамжийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл нь хөдөлмөрийн чадвараа алдсан иргэний эрх ашиг зөрчигдөж байгаа эсэхэд хяналт тавьж, тэднийг шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.

бүрдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй, ЭХМК-ын дүрмийн ¹³7.1.2, ¹⁴8.1.1-дэхь заалтуудыг хэрэгжүүлээгүй дараахь зөрчлүүд байна. Тухайлбал:

- ✓ *Мэргэжлийн байгууллагууд хөндлөнгийн хяналт хийж дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, комиссын үйл ажиллагаанд хийх дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй,*
- ✓ *Хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, комиссын гишүүдийн ажиллах нөхцөлийг сайжруулах талаар шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлэх, хяналт хийж орчин нөхцөлийг сайжруулах чиг үүргээ төрийн байгууллагууд биелүүлээгүй*
- ✓ *ХБИ-ний эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл нь иргэний эрх ашиг хөндөгдөж байгаа талаар хяналт хийгээгүй байна.*

Аудитын явцад дээрх зөрчил дутагдалтай холбоотой нийт 2.5 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс 0.6 сая төгрөгийн акт бичиж 1.9 сая төгрөгийн зөвлөмж өгөгдлөө.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ✚ **Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хурлын байр, тоног төхөөрөмж шаардлага хангаагүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх орчин нөхцөл бүрдээгүй байна.**
- ✚ **Орон нутгийн эмнэлэг магадлах комиссын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.**

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Б.Дүгэржав, Сумдын Засаг дарга нарт:

- ✚ **ЭХМК-ын үйл ажиллагаа явуулах байраар хангаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, комиссын**

¹³ комиссыг үйл ажиллагаа явуулах байраар хангаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, комиссын гишүүдийн ажиллах нөхцөлийг сайжруулах талаар шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

¹⁴ эмнэлгийн байгууллагын Эмнэлэг хяналтын комисс болон Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

гишүүдийн ажиллах нөхцөлийг сайжруулах талаар шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх

- ✚ Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой үйл ажиллагааг дэмжиж, холбогдох байгууллагатай хамтран ажиллах, аймгийн хэмжээний сэргээн засах төв байгуулах, ЭХМК-ийн гишүүдийн аюулгүй байдалд анхаарч хэрэгжилтэнд нь хяналт тавих
- ✚ Сумдын засаг дарга нар орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Эмнэлэг хөдөлмөр магадлалын комиссын дарга Н.Батчулуун-д

- ✚ ЭХМК-нь гэрээ дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсруулан батлах, салбар комиссын дарга гишүүдтэйгээ үр дүнгийн гэрээ байгуулж, үр дүнгийн гэрээгээ дүгнэж баталгаажуулах, сонгон шалгаруулалт явуулсан хурлын тэмдэглэл, тайланг комиссын гишүүдийн гарын үсгээр баталгаажуулан баримтжуулах
- ✚ Хөдөлмөрийн чадвар алдалтын судалгаа хийж дүгнэлт гаргах, өрхийн болон төрөлжсөн мэргэжлийн эмчийн идэвхтэй хяналтад оруулсан эсэх, эмчилгээний үр дүнг тооцсон судалгаа, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг бууруулсан судалгаа, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрхэн хийсэн талаар мэдээлэлтэй болох
- ✚ Комиссын үйл ажиллагааг боловсронгуй болгох, үйлчилгээг сайжруулах талаар арга хэмжээ авч санал боловсруулж зохих газраар шийдвэрлүүлэх
- ✚ ХБИ-ний эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл нь жил бүр иргэдтэй уулзаж санал хүсэлтийг авч түүний мөрөөр хийж хэрэгжүүлсэн ажлаа баримтжуулан тайлагнаж байх

МХГ-ын дарга П.Эрдэнэчулуун-д

- ✚ Хөдөлмөр магадлах комиссын тэтгэвэр тогтоолт, хувь хэмжээ, оношийн үнэн зөв байдалд хяналт шалгалт хийж заавар зөвлөмж өгч дүгнэлт гаргах
- ✚ Эрүүл мэнд хариуцсан хяналтын байцаагчийн ажлын хариуцлагыг дээшлүүлж боловсон хүчний тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх

ЭМГ-ын дарга Ц.Мягмарсүрэн-д

- ✚ Хурал зохион байгуулах байр болон үйл ажиллагаа явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, бусад нөхцөл боломжоор комиссыг хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих
- ✚ Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, үйл ажиллагаанд нь хяналт тавих

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР

Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ц.АЗЗАЯА

Тэргүүлэх аудиторын тушаал:



Аудитын тайлан, акт, зөвлөмж батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.23, 15.2.5 дахь заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын А/188 дугаар тушаалын 5 дугаар хэвсрэлтын 1.2, 2.4 дэх заалт, Газрын дарга бөгөөд, тэргүүлэх аудиторын дэргэдэх зөвлөлийн хурлын 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөдөлмөр магадлах комиссын тахир дутуугийн тэтгэвэр тогтоолтын хэрэгжилтэд" хийсэн нийцлийн аудитын тайлан, акт, зөвлөмжийг хэвсрэлтээр баталсугай.

2. Нийцлийн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн Засаг дарга Б.Дүгэржав, сумдын засаг дарга нарт ДААЛГАХ нь:

2.1 Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын үйл ажиллагаа явуулах байраар хангаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, комиссын гишүүдийн ажиллах нөхцөлийг сайжруулах талаар шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх

2.2 Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой үйл ажиллагааг дэмжиж, холбогдох байгууллагатай хамтран ажиллах, аймгийн хэмжээний сэргээн засах төв байгуулах, ЭХМК-ийн гишүүдийн аюулгүй байдалд анхаарч хэрэгжилтэд нь хяналт тавих

2.3 Сумдын засаг дарга нар орон нутагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх

3. Эмнэлэг хөдөлмөр магадлалын комиссын дарга Н.Батчулуун-д ДААЛГАХ нь:

3.1 Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын гэрээ дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсруулан батлах, салбар комиссын дарга гишүүдтэйгээ үр дүнгийн гэрээ байгуулж, үр дүнгийн гэрээгээ дүгнэж баталгаажуулах, сонгон шалгаруулалт явуулсан хурлын тэмдэглэл, тайланг комиссын гишүүдийн гарын үсгээр баталгаажуулан баримтжуулах.

4.2 Хөдөлмөрийн чадвар алдалтын судалгаа хийж дүгнэлт гаргах, өрхийн болон төрөлжсөн мэргэжлийн эмчийн идэвхтэй хяналтад оруулсан эсэх, эмчилгээний үр дүнг тооцсон судалгаа, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг бууруулсан судалгаа, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрхэн хийсэн талаар мэдээлэлтэй болох

0900032

4.3 Комиссын үйл ажиллагааг боловсронгуй болгох, үйлчилгээг сайжруулах талаар арга хэмжээ авч санал боловсруулж зохих газраар шийдвэрлүүлэх.

4.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл нь жил бүр иргэдтэй уулзаж санал хүсэлтийг авч түүний мөрөөр хийж хэрэгжүүлсэн ажлаа баримтжуулан тайлагнаж байх.

5. Мэргэжлийн хяналтын газрын дарга П.Эрдэнэчулуун-д ДААЛГАХ нь:

5.1 Хөдөлмөр магадлах комиссын тэтгэвэр тогтоолт, хувь хэмжээ, оношны үнэн зөв байдалд хяналт шалгалт хийж заавар зөвлөмж өгч дүгнэлт гаргах

5.2 Эрүүл мэнд хариуцсан хяналтын байцаагчийн ажлын хариуцлагыг дээшлүүлж боловсон хүчний тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх

6. Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мягмарсүрэн-д ДААЛГАХ нь:

6.1 Хурал зохион байгуулах байр болон үйл ажиллагаа явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, бусад нөхцөл боломжоор комиссыг хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих

6.2 Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, үйл ажиллагаанд нь хяналт тавих.

7. Аудитаар өгсөн акт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллаж, үр дүнг нь аймаг дахь Төрийн аудитын газарт 2018 оны 12 дүгээр сарын 25-ны дотор албан тоотоор ирүүлэх.

8. Нийцлийн аудитын акт, зөвлөмжийн, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аудитор Д.Эрдэнэцэцэг, аудитор Ц.Аззаяа нарт хариуцуулсугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

Зөрчлийн нэгтгэл:

				Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудиторын 2018 оны 10 дугаар сарын-ны өдрийн дугаар тушаалын хавсралт			
АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ							
Аудитын код: УАГ- ХОА/2018/03-НА							
Аудитын нэр: Хөдөлмөр магадлах комиссын тахир дутуугийн тэтгэвэр тогтоолтын хэрэгжилт							
Д/д	Зөрчлийн товч утга	Зөрчигдсэн хуулийн заалт	Зөрчлийн дүн сая.төг	Үүнээс			
				Аудитын явцад барагдуулсан	Акт тогтоосон	Албан шаардлага өгсөн	Зөвлөмж өгсөн
1	Комиссын гишүүдэд олгосон цагийн бүртгэл хурлын тэмдэглэлгүй, тамга тэмдэг дарж баталгаажуулаагүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно..." гэсэн заалтыг зөрчсөн	1.9				1.9
7	ХАОАТ-ын хөнгөлөлт илүү эдлүүлсэн, цагийн хөлс илүү олгосон	Хувь хүний албан татварын тухай хуулийн 24.1-д "Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт 84000 төгрөгийг албан татварын хөнгөлөлт үзүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн	0.6		0.6		0.6
Дүн			2.5	0	0.6	0	2.5

Байгууллагын санал:



АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын тахир дутуугийн тэтгэвэр тогтоолтын хэрэгжилт-нд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж хэрэгжилтэнд тусгах саналыг хүргүүлэв.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *[Signature]* Н.БАТЧУЛУУН



My doc My doc.Oj.A-5

Байгууллагын саналд өгөх тайлбар:

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсээс ирүүлсэн 136 тоот албан бичгийн хавсралт саналууд аудитын тайланд тусгагдсан болно.